



**ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 8/59

Баян-Өндөр сум

Уртбулаг баг. 5-р сургуульд сургалтын
тоног төхөөрөмж хүлээн авах
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 160 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.4-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Уртбулаг баг. 5-р сургуульд сургалтын тоног төхөөрөмж” хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Чимэддулам (5-р сургуулийн Захирал)

Гишүүд:

Д.Аззаяа (5-р сургуулийн Нягтлан бодогч)

Г.Эрдэнэсүвд (5-р сургуулийн нярав)

Д.Амар (5-р сургуулийн Мэдээлэл зүйн багш)

Э.Энхчимэг (Орон нутгийн өмчийн газрын Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

Х.Одхүү (Худалдан авах ажилагааны газрын Хуулийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ж.Давааням (Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Хот төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

2.Нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжний техникийн тодорхойлолт, гэрээний хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийн дагуу хянаж, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хүлээн авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хүлээн авах комисс (Ц.Чимэддулам)-д даалгасугай.

3.Хүлээн авсан тоног төхөөрөмжийг 5-р сургуулийн хөрөнгө орлогод хүлээн авч, бүртгэн ажиллахыг Нягтлан бодогч (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАНСҮРЭН



6124010033